



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/23/СТА-ТШЗ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ 7
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.МӨНХСҮХ ТАНАА

2021.02.25 № 2/140
танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020111

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,969,290.50</u>	<u>39,670,398.50</u>
33	АВЛАГА	00.00	505,708.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	357,208.00
335	Бусад авлага	00.00	148,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	148,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,969,290.50	39,164,690.50
351	Түүхий эд материал	708,390.00	2,047,390.00
35110	Тусгай зориулалттай материал	708,390.00	2,047,390.00
354	Хангамжийн материал	50,319,700.50	33,157,300.50
35410	Бичиг хэргийн материал	2,444,614.00	3,421,714.00
35420	Аж ахуйн материал	17,909,020.00	17,709,520.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	60,000.00
35470	Бусад хангамжийн материал	29,966,066.50	11,966,066.50
35600	Мал амьтад	10,941,200.00	3,960,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,627,850,629.82</u>	<u>3,385,462,736.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,627,850,629.82	3,385,462,736.11
392	Биет хөрөнгө	3,554,121,096.49	3,293,932,023.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,909,720,980.10	3,925,216,510.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-948,780,213.94	-1,137,377,558.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	270,075,020.00	242,097,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-126,870,819.67	-137,635,315.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,840,944.90	299,245,964.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-94,727,474.27	-138,876,093.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	122,632,239.09	130,632,239.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-60,243,079.53	-74,311,285.34
39209	Зам, гүүрийн байгууламж	13,612,310.00	13,612,310.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2,217,841.42	-2,898,456.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	242,494,676.00	242,494,676.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-49,415,644.77	-68,268,766.89
393	Биет бус хөрөнгө	73,729,533.33	91,530,712.50
39301	Програм хангамж	1,754,060.00	2,004,060.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,195,726.67	-1,267,601.67
39303	Бусад биет бус хөрөнгө	73,871,200.00	91,792,950.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-700,000.00	-998,695.83
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,689,819,920.32</u>	<u>3,425,133,134.61</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,689,819,920.32</u>	<u>3,425,133,134.61</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,689,819,920.32	3,425,133,134.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	505,387,011.50	505,387,011.50
51101	Өмч: - төрийн	505,387,011.50	505,387,011.50
512	Хуримтлагдсан үр дүн	3,098,683,036.12	2,833,996,250.41
51210	Өмнөх үеийн үр дүн	3,098,683,036.12	3,098,683,036.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-264,686,785.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,749,872.70	85,749,872.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,689,819,920.32</u>	<u>3,425,133,134.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	670,169,291.00	478,273,368.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	348,793,115.00	66,102,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	348,793,115.00	66,102,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	348,793,115.00	66,102,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	4,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	348,193,115.00	61,902,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	321,376,176.00	412,170,568.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,280,000.00	32,553,168.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	7,110,168.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,780,000.00	25,443,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	309,096,176.00	379,617,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309,096,176.00	379,617,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	610,260,594.67	742,960,153.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,260,594.67	742,960,153.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,377,292.67	724,017,295.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,224,907.00	237,555,514.00
210101	Үндсэн цалин	180,224,907.00	237,555,514.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,592,538.00	30,115,874.00
210201	Тэтгэврийн даатгал	15,398,594.00	30,115,874.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,799,655.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,439,722.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	355,261.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,599,306.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,185,508.00	30,224,750.00
210301	Гэрэл, цахилгаан	2,375,108.00	5,005,350.00
210302	Түлш, халаалт	30,710,400.00	24,825,400.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	394,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,278,442.23	92,651,889.00
210401	Бичиг хэрэг	5,809,660.00	4,442,800.00
210402	Тээвэр, шатахуун	26,323,500.60	37,435,439.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325,000.00	1,526,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,786,339.63	42,146,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	17,733,942.00	00.00
210408	Бараа материал ахталсны зардал	00.00	6,981,200.00
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,275,260.00	646,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	666,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,609,260.00	646,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,841,400.00	3,178,000.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	6,875,900.00	3,178,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	965,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,700,780.00	15,101,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,700,780.00	15,101,475.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,278,457.44	313,543,093.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,666,976.00	7,882,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,761,481.44	305,660,193.71
210904	Найдваргүй авлагын алдагдал	5,800,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,883,302.00	18,942,858.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,832,850.00	4,739,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,123,278.00	00.00

Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,109,572.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	4,239,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,030,452.00	14,203,758.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,030,452.00	12,208,758.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,000.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	59,908,696.33	-264,686,785.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	968,970.42	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	968,970.42	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-968,970.42	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	58,939,725.91	-264,686,785.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	323,099,454.00	416,370,568.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	4,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	4,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	4,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	4,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	322,499,454.00	412,170,568.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,280,000.00	32,553,168.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	7,110,168.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,780,000.00	25,443,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	309,096,176.00	379,617,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309,096,176.00	379,617,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,123,278.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,123,278.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	318,211,954.00	414,870,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	318,211,954.00	414,870,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,028,652.00	395,927,710.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,086,058.00	237,952,996.00
210101	Үндсэн цалин	180,086,058.00	232,756,406.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,424,306.00
210104	Урамшуулал	00.00	3,772,284.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,454,792.00	29,537,622.00
210201	Тэтгэврийн даатгал	15,152,704.00	20,432,263.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,841,300.00	2,319,684.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,439,009.00	1,903,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	368,300.00	421,694.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,653,479.00	4,460,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,560,508.00	30,284,750.00
210301	Гэрэл, цахилгаан	2,375,108.00	5,005,350.00
210302	Түлш, халаалт	25,085,400.00	24,885,400.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	394,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,671,600.00	31,064,600.00

Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	4,207,900.00	4,342,600.00
210402	Тээвэр, шатахуун	24,307,700.00	24,836,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	356,000.00	1,516,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	250,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,555,860.00	804,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	462,500.00	00.00
210604	Урсгал засвар	5,093,360.00	804,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,817,900.00	3,008,000.00
210701	Гадаад албан томиллолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томиллолт	6,875,900.00	3,008,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,942,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,025,180.00	38,819,603.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,925,100.00	38,819,603.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,080.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,856,754.00	23,456,139.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,806,754.00	23,456,139.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,183,302.00	18,942,858.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,132,850.00	4,739,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,123,278.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	4,239,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,009,572.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,030,452.00	14,203,758.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,030,452.00	12,208,758.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,000.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,887,500.00	1,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,887,500.00	1,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,887,500.00	1,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,887,500.00	1,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,887,500.00	1,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,887,500.00	-1,500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,836,623.90	3,039,656,559.01	3,630,880,194.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	86,751.20	86,751.20
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	-86,751.20	00.00	-86,751.20
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	58,939,725.91	58,939,725.91
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	3,098,683,036.12	3,689,819,920.32
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	3,098,683,036.12	3,689,819,920.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	3,098,683,036.12	3,689,819,920.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-264,686,785.71	-264,686,785.71
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,387,011.50	85,749,872.70	2,833,996,250.41	3,425,133,134.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380,617,400.00	371,608,642.00	9,008,758.00	97.6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,617,400.00	371,608,642.00	9,008,758.00	97.6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,878,300.00	366,869,542.00	9,008,758.00	97.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,953,600.00	237,952,996.00	604.00	100.0%
210101	Үндсэн цалин	231,565,500.00	232,756,406.00	-1,190,906.00	100.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,516,000.00	1,424,306.00	1,091,694.00	56.6%
210104	Урамшуулал	3,872,100.00	3,772,284.00	99,816.00	97.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,559,800.00	29,537,622.00	1,022,178.00	96.7%
210201	Тэтгэврийн даатгал	21,041,700.00	20,432,263.00	609,437.00	97.1%
210202	Тэтгэмжийн даатгал	2,379,500.00	2,319,684.00	59,816.00	97.5%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,600.00	1,903,600.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	475,900.00	421,694.00	54,206.00	88.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,759,100.00	4,460,381.00	298,719.00	93.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,285,400.00	30,284,750.00	650.00	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	4,900,000.00	5,005,350.00	-105,350.00	102.2%
210302	Түлш, халаалт	24,885,400.00	24,885,400.00	0.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	394,000.00	106,000.00	78.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	31,342,600.00	31,064,600.00	278,000.00	99.1%
210401	Бичиг хэрэг	4,342,600.00	4,342,600.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	24,836,000.00	24,836,000.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,664,000.00	1,516,000.00	148,000.00	91.1%

Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	120,000.00	130,000.00	48.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	250,000.00	0.00	100.0%
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,719,600.00	2,304,000.00	2,415,600.00	48.8%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0%
210604	Урсгал засвар	3,219,600.00	804,000.00	2,415,600.00	25.0%
2107	Томилолт, зочны зардал	4,070,000.00	3,008,000.00	1,062,000.00	73.9%
210702	Дотоод албан томилолт	4,070,000.00	3,008,000.00	1,062,000.00	73.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,262,200.00	8,261,435.00	765.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,262,200.00	8,261,435.00	765.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27685100.00	23456139.00	4,228,961.00	84.7%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,685,100.00	23,456,139.00	4,228,961.00	84.7%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4739100.00	4739100.00	0.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,739,100.00	4,739,100.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,239,100.00	4,239,100.00	0.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380,617,400.00	371,608,642.00	9,008,758.00	97.6%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	379,617,400.00	370,608,642.00	9,008,758.00	97.6%
132001	Орон нутгийн төсвөөс	379,617,400.00	370,608,642.00	9,008,758.00	97.6%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	0.00	100.0%
620001	Удирдах ажилтан	3	3	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	0.00	100.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	0.00	100.0%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	32,553,168.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	32,553,168.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	32,553,168.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	30,558,168.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	30,558,168.00
213405	нэмэлт санхүүжилт төвлөлүүлэлт	0.00	1,995,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	32553168.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	32,553,168.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	7,110,168.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	25,443,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянлиг сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Мөнхсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-аас 2021 оны 02 дугаар сарын 22–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Төрийн захиргааны нэгдмэл удирдлагыг хангаж, төрийн мэргэшсэн албан хаагчаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхайн үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй мэдээлж хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянлиг сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд Баянлиг сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 453662.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9073.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 742960.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14859.2 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянлиг сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3425133.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 264686.8 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Төлөвлөлт
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,969.3	39,670.4	(22,298.9)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	505.7	505.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	61,969.3	39,164.7	(22,804.6)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,627,850.6	3,385,462.7	(242,387.9)
Үндсэн хөрөнгө	4,912,001.4	4,947,096.5	35,095.1
Хуримтлагдсан элэгдэл	(1,284,150.8)	(1,561,633.8)	(277,483.0)
Нийт хөрөнгө	3,689,819.9	3,425,133.1	(264,686.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,689,819.9	3,425,133.1	(264,686.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,689,819.9	3,425,133.1	(264,686.8)

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Жилийн эцэст цалингийн тооцооны авлага 357.2 мянга, тээврийн хэрэгслийн татвар давхар шилжүүлснээс 148.5 мянга нийт 505.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39164.7 мянган төгрөг болж 22804.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд бусад хангамжийн материалд бүртгэлтэй 41296.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг зарлагадсан /2019 онд ОНХС-гийн хөрөнгөөр бэлдсэн өвс,

тэжээл 18000.0 мянган төгрөг, 2020 онд Сум дундын ойн ангиас ирсэн өвс 15696.0 мянган төгрөг/, 6981.2 мянган төгрөгийн мал амьтдыг 2020.12.23 ны өдрийн 21 тоот мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн акталж устгасан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4947096.5 мянган төгрөг болж 35095.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг сумын Засаг даргын 2020.12.21-ны өдрийн 157 тоот захирамжийг үндэслэн 44421.7 мянган төгрөгийн хөрөнгө, "Дэлхийн зөн" ОУБ-аас 12495.5 мянган төгрөгийн өвсний агуулахыг үнэ төлбөргүй орлого, төсвийн хөрөнгөөр 1500.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, өмнөх аудитын зөвлөмжийн дагуу 450.0 мянган төгрөгийн санхүүгийн программ тус тус хөрөнгөд орлогоор бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор 14120.0 мянган төгрөгийн Кама хогны машин, 13857.2 мянган төгрөгийн 3 ш трактор акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3425133.1 мянган төгрөг болж 264686.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 264686.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 478273.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 191895.9 мянган төгрөгөөр буюу 28.6 хувиар буурсан байна.

Энэ нь төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 3600.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 70521.2 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан санхүүжилт 20273.2 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн, үнэ төлбөргүй авсан орлого 286290.3 мянган төгрөгөөр буурсантай тус тус холбоотой байна.

Нийт зардал 742960.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 132699.6 мянган төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 57330.6 мянга, НДШ 7523.3 мянга, хангамж бараа материалын зардал 27373.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 10400.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 472468.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 472468.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 359524.4 мянган төсөв батлагдаж 2 удаа тодотгол хийн 380617.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 379617.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 379617.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 371608.6 мянган төгрөгийг зарцуулж 9008.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 371608.5 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь НДШ-ийн зардал 1022.2 мянга, хангамж, бараа материал 278.0 мянга, урсгал засвар 2415.6 мянга, томилот 1062.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 4228.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ		380,617,400.00	371,608,642.00	9,008,758.00	98%
Хөтөлбөр70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	380,617,400.00	371,608,642.00	9,008,758.00	98%
АРГА ХЭМЖЭЭ 80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	288,821,500.00	281,976,202.00	6,845,298.00	98%
АРГА ХЭМЖЭЭ 80106	Баг, хорооны ҮАЗардал	66,007,400.00	63,333,701.00	2,673,699.00	96%
АРГА ХЭМЖЭЭ 80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0.00	4,739,100.00	-4,739,100.00	#DIV/0!
АРГА ХЭМЖЭЭ 81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	15,239,700.00	15,239,544.00	156.00	100%
АРГА ХЭМЖЭЭ 82212	Хур хог хаягдал, орчны бохирдол	10,548,800.00	6,320,095.00	4,228,705.00	60%

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЫН ДАНСААР ӨВЖ ТЭЖЭЭЛИЙН ОРЛОГО 23298.0 мянга, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ 5000.0 мянга, МАЛЖУУЛАХЫН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ 1995.0 мянга, МАЛ ТООЛЛОГЫН ЗАРДАЛ 1110.2 мянга, ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ 1000.0 мянга, ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛЫН ҮНЭ ОРСОНООС ӨВС ТЭЖЭЭЛИЙН ҮНЭ 22798.0 мянган төгрөг, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ 1995.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн болно.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 130 мэдээлэл хугацаандаа байршуулж цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс 21522.0 мянган төгрөгийн гүйлгээ 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	1	4
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	4	4	4	0	
4	Сар бүр	12	36	36	0	
5	Тухай бүр	12	96	80	10	
	Нийт		151	130	11	4

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитаар нийт 258179.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3000.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 250575.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 4604.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	250575.0	1	243935		6640,0	
Акт	1	3000.0	1	3000,0			
Зөвлөмж	3	4604.0	3	4604.0			
Нийт дүн	5	258179.0	5	251539		6640,0	97,4

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79292.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 148.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 63232.7 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15911.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 79292.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрснээс 148.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 63232.7 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15911.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн татварыг давхардуулан шилжүүлсний улмаас 148.5 мянган төгрөгийн авлагатай гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Төсвөөс илүү шилжүүлсэн тээврийн хэрэгслийн албан татвар 148.5 мянган төгрөгийг суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн ирүүлсэн өвс тэжээлийн тооцоогоор 2020 онд нийт 66300.4 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж 50604.4 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сум дундын ойн ангиас олгосон өвс тэжээлийн тооцоог 2021.04.15-ны дотор нийлж, үлдэгдэл тооцоог баталгаажуулан данс бүртгэлд тусган биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэх.

3. Тоног төхөөрөмжид бүртгэлтэй 12628.3 мянган төгрөгийн дизель моторыг 2011 оны 4-р сарын 14-ны өдөр аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Эрчим Хүч ЦТХК-нд акт үйлдэн хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл тус моторыг данснаас хасаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: “Баянхонгор аймгийн Эрчим Хүч ЦТХК-д хүлээлгэн өгсөн 12628.3 мянган төгрөгийн дизель моторыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15911.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд санхүүгийн тайлангаар 85749.9 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн дахин үнэлгээний нөөц хэсэгт 69838.6 мянган төгрөг буюу 15911.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5.1.4.үнэн зөв байх; “Эрх ба үүрэг” батламж мэдэглийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Хөрөнгийн дахин үнэлгээ буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансыг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дахин үнэлгээний нөөц хэсэгтэй тулган зөрүүгүй болгох.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 130 мэдээлэл хугацаандаа байршуулж цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс 21522.0 мянган төгрөгийн гүйлгээ 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

2.2. Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЛТАНТУЯА 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Баянлиг сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/23/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянлиг сумын ЗДТГ		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
	1	2	3	Албан тушаал	Овог нэр
1	Тээврийн хэрэгслийн татварыг давхардуулан шилжүүлсний улмаас 148.5 мянган төгрөгийн авлагатай гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.	148.5	Төлбөр акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх Г.Тунгалаг
2	Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн ирүүлсэн өвс тэжээлийн тооцоогоор 2020 онд нийт 66300.4 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж 50604.4 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	50604.4	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх Г.Тунгалаг
3	Тоног төхөөрөмжид бүртгэлтэй 12628.3 мянган төгрөгийн дизель моторыг 2011 оны 4-р сарын 14-ны өдөр аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Эрчим Хүч ЦТХК-нд акт үйлдэн хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл тус моторыг данснаас хасаагүй байна.	12628.3	Албан шаардлага хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх Г.Тунгалаг
4	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд санхүүгийн тайлангаар 85749.9 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн дахин үнэлгээний нөөц хэсэгт 69838.6 мянган төгрөг буюу 15911.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	15911.3	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх Г.Тунгалаг
5	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 130 мэдээлэл хугацаандаа байршуулж цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс 21522.0 мянган төгрөгийн гүйлгээ 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Г.Мөнхсүх Г.Тунгалаг
ДҮН		79292.5			

_____оОо_____